



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/158

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сурлагын амжилтаар тэргүүлсэн Сүмбэр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч Т.Маралмаа, М.Пунцагхорлоо, Э.Хангарьд, 2 дугаар сургуулийн сурагч Г.Алтанцэцэг, Г.Гантуяа, Лаборатори 5 дугаар сургуулийн сурагч Г.Даваатогтох, С.Очмаа, Б.Марал, Шивээговь сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн сурагч Э.Ариунчимэг, А.Светлана, Баянтал сумын ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн сурагч Х.Хулан, Э.Олныхүү нарыг мөнгөн шагналаар шагнасугай.

2. Шагналын зардал 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Уранцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

